



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/36

Хажуу шинэ-Ус

2024 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлага  
явуулах тухай

Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, Цэргийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсэг, Аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/236 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татлагыг 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 09:00 цагт Сургуулийн спорт зааланд зохион байгуулсугай.

2.Цэрэг татлага зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч : Н.Өлзийтогтох (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд:

Ч.Мягмарсүрэн (Архив, бичиг хэргийн эрхлэгч )

Э.Ванчиндорж (Хэсгийн төлөөлөгч)

Б.Мөнхдэлгэр (1 дүгээр багийн Засаг дарга)

М.Амарзаяа (2 дугаар багийн Засаг дарга)

Н.Энхтайван (3 дугаар багийн Засаг дарга )

Л.Батбаатар (4 дүгээр багийн Засаг дарга)

Н.Болор-Эрдэнэ (Төрийн сангийн мэргэжилтэн)

А.Бямбасүрэн (Их эмч)

Т.Уранчимэг (Ерөнхий боловсролын сургуулийн захирал)


Д.Чанцалдулам (Насан туршийн боловсролын багш)

3.Цэрэг татлагын товчоогоор орох цэргийн насны иргэдэд зарлан дуудах мэдэгдлийг албан ёсоор хүргүүлж иргэдээ бүрэн хамруулах ажлыг багийн Засаг дарга нар, нийгмийн хэв журам сахиулахыг хэсгийн төлөөлөгч (Э.Ванчиндорж) нарт үүрэг болгосугай.

4.Цэргийн насны залуучуудад "Бичиг үсгийн боловсролыг дээшлүүлэх" талаар авсан арга хэмжээ, сургалт явуулсан тухай тайланг цэргийн штаб гаргаж өгөхийг Ерөнхий боловсролын сургуулийн насан туршийн боловсрол хариуцсан мэргэжилтэн (Д.Чанцалдулам)-д даалгасугай.

5.Цэрэг татлага Сургуулийн биеийн тамирын спорт зааланд зохион байгуулагдах тул байраар хангахыг Сургуулийн захирал (Т.Уранчимэг), бусад үйл ажиллагаанд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангахыг (Н.Өлзийтогтох) нарт даалгасугай.

ДАРГА



ТАРИУНАА

482401038